



**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 09 сарын 23 өдөр

Дугаар A/65

Улаанбаатар хот


**Журам батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам”-ын 3.1-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ыг нэгдүгээр, “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй ярилцлага хийх сэдэв”-ийг хоёрдугаар, “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчид комиссын гишүүний үнэлгээ өгөх хуудас”-ыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Д.Түвшинтөр/- д үүрэг болгосугай.


ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨРӨН

000000425

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын  
2016 оны 09 сарын 23-ны өдрийн 14 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт



## МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ БОЛОХ ХҮСЭЛТ ГАРГАГЧТАЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилт нь Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид “хүсэлт гаргагч” гэх/ монголын ард түмний ёс заншил, төрийн албан ёсны хэл, Монгол Улсын Үндсэн хуулийн талаар зохих мэдлэг эзэмшсэн эсэхийг ярилцлага хийж тогтооход оршино.

### Хоёр. Ярилцлагын бэлтгэл ажиллагаа

2.1. Ярилцлагыг комиссын дарга удирдан зохион байгуулна. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “Газар” гэх/-ын дэд дарга комиссын дарга, харьяатын асуудал хариуцсан нэгжийн дарга, хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн хяналтын улсын байцаагч, харьяатын асуудал хариуцсан нэгжийн ахлах мэргэжилтэн нар нь комиссын гишүүн, харьяатын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн нь комиссын нарийн бичгийн дарга байна.

2.2. Комиссын нарийн бичгийн дарга хүсэлт гаргагчийн материалын бүрдлийг хангаж, хүсэлт гаргагчтай ярилцлага хийхэд бэлтгэнэ.

2.3. Комиссын нарийн бичгийн дарга хүсэлт гаргагчийн талаарх танилцуулга, материал, холбогдох хууль хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг комиссын дарга, гишүүдэд танилцуулна.

2.4. Комиссын даргын шийдвэрээр хүсэлт гаргагчтай ярилцлага хийх өдөр, цагийг товлон ажлын нэг хоногийн өмнө хүсэлт гаргагчид энэ талаар мэдэгдэнэ.

### Гурав. Ярилцлага хийх үйл ажиллагаа

3.1. Комиссын гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр ярилцлагыг хийнэ.

3.2. Комиссын нарийн бичгийн дарга гишүүдэд ирц, ярилцлага авах хүсэлт гаргагчийн талаар комиссын гишүүдэд танилцуулан, тэмдэглэл хөтөлнө.

3.3. Ярилцлага эхлэхийн өмнө комиссын гишүүд нь хүсэлт гаргагчтай “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргана.

3.4. Комиссын гишүүд батлагдсан ярианы сэдвийн хүрээнд хүсэлт гаргагчтай ярилцлага хийнэ.

3.5.Ярилцлага хийх явцад хүсэлт гаргагчаас комиссын гишүүд ээлжлэн асуулт асуун, хариулт авч үнэлгээний хуудсанд үнэлгээгээ тавьж, гарын үсгээр баталгаажуулна.

#### Дөрөв. Комиссын гишүүний эрх, үүрэг

4.1.Комиссын гишүүн дараахь эрхийг эдэлнэ:

4.1.1.хүсэлт гаргагчийн өргөдөл, материалтай танилцах;

4.1.2. хүсэлт гаргагчийг үнэн зөв, ярихыг сануулах;

4.1.3.хүсэлт гаргагчийн хувийн амьдралын талаар асуулт асууж, хариуг авах;

4.1.4.хүсэлт гаргагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэлтэй танилцах;

4.1.5. хүсэлт гаргагчтай батлагдсан сэдвийн дагуу ярилцлага хийх.

4.2.Комиссын гишүүн дараахь үүргийг хүлээнэ:

4.2.1. ярилцлаганд товлосон цагт ирэх;

4.2.2. хүсэлт гаргагчтай хийх ярилцлагын сэдвийн нууцыг хадгалах;

4.2.3.ярилцлага хийсэн хүсэлт гаргагчийн нууцыг хадгалах.

#### Тав.Ярилцлагыг үнэлэх, дүгнэх

5.1.Ярилцлагыг хангалттай, хангалтгүй гэсэн үнэлгээгээр дүгнэнэ.

5.2.Хүсэлт гаргагчийн монголын ард түмний ёс заншил, төрийн албан ёсны хэл, Монгол Улсын Үндсэн хуулийн талаар зохих мэдлэг эзэмшсэн эсэхийг хавсралтад заасан оноогоор үнэлнэ.

5.3.Комиссын нарийн бичгийн дарга комиссын гишүүдийн өгсөн оноог нэгтгэн дундаж онооны дүнгээр үнэлгээг гаргана. 70-100 оноо хангалттай, 0-70 оноо хангалтгүй гэсэн үнэлгээтэй байна.

5.4.Комиссын гишүүд нь дараахь байдлыг харгалзан үнэлгээ өгнө:

5.4.1.ард түмний ёс заншлыг хэр судалж, түүний учир утгыг ойлгож байгаа;


5.4.2.төрийн албан ёсны хэл монгол хэлээр хэр зэрэг оновчтой, тодорхой ярьж байгаа;

5.4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн талаар зохих мэдлэг эзэмшсэн эсэхийг хуулийн зүйл заалтуудыг ерөнхийд нь ойлгож утгыг гарган хэлж байгаа.

5.5.Хүсэлт гаргагч нь ярилцлаганд тэнцээгүй тохиолдолд ажлын 10 хоногийн дараа дахин нэг удаа ярилцлага өгч болно.

5.6.Комиссын гишүүдийн үнэлгээний хуудсыг комиссын нарийн бичгийн дарга нэгтгэн, хүсэлт гаргагчтай болон түүний гэр бүлийн гишүүдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, дүгнэлтийг ажлын хоёр хоногт боловсруулж комиссын даргад танилцуулж, гарын үсэг зурж баталгаажуулна.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын  
2016 оны 09 сарын 23-ны өдрийн 465 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ БОЛОХ ХҮСЭЛТ ГАРГАСАН ГАДААДЫН ИРГЭН,  
ХАРЬЯАЛАЛГҮЙ ХҮНТЭЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ СЭДЭВ

Нэг. Монголын ард түмний ёс заншлын талаар

- Мэндлэх ёс;
- Төрөө дээдлэх ёс;
- Ахмадыг хүндэлж дээдлэх ёс;
- Төрийн баяр ёслол;
- Ардын уламжлалт баяр ёслол, зан заншил.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө талаар

- Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө;
- Өмчлөх эрх;
- Эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрх;
- Халдашгүй чөлөөтэй байх эрх;
- Монгол Улсын иргэний үндсэн үүрэг;
- Монгол Улсын иргэний журамт үүрэг.

Гурав. Монгол Улсын төрийн бэлгэдлийн талаар

- Монгол Улсын төрийн сүлд;
- Монгол Улсын төрийн далбаа;
- Монгол Улсын төрийн тамга;
- Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хот.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсын төрийн байгуулалын талаар

1. Монгол Улсын Их Хурал:

- Улсын Их Хурлын гишүүнийг хэрхэн сонгодог талаар;
- Улсын Их Хурлын гишүүнийг хэдэн жилээр сонгодог талаар;

- Улсын Их Хурлын гишүүнээр ямар хүнийг сонгодог талаар;

- Улсын Их Хурлын эдлэх онцгой бүрэн эрх.

2.Монгол Улсын Ерөнхийлөгч:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх.

3.Монгол Улсын Засгийн газар:

- Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа.

-Засгийн газрын бүрэн эрх.

4.Шүүх эрх мэдэл:

- Шүүхийн үндсэн тогтолцоо.

5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага:

-Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага;

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн талаар;

-Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрөө удирдах ёс, төрийн удирдлага хэрхэн хангагдах талаар.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц:

- Үндсэн хуулийн цэцийн талаар.

- Үндсэн хуулийн цэцийн гишүүд, хэн хэдий хугацаагаар ямар иргэнийг томилдог талаар.

--oOo--

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын  
2016 оны 09 сарын 23-ны өдрийн 16 дугаар  
тушаалын 3 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ БОЛОХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИД  
КОМИССЫН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ХУУДАС

20.. оны....дугаар сарын....-ны өдөр  
Эхэлсэн....цаг...минут

Дууссан....цаг...минут

Ярилцлаганд орсон гадаадын иргэн,  
харьяалалгүй хүний овог, нэр .....

Д/д	Ярилцлагын сэдэв	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо
1	Монголын ард түмний ёс заншлын талаар	0-40	
2	Төрийн албан ёсны хэлний талаар	0-30	
3	Монгол Улсын Үндсэн хуулийн талаар	0-30	
НИЙТ			

Комиссын гишүүний овог, нэр  
/гарын үсэг/.....

--oOo--